



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/48

Жаргалтхаан

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хүүхдийн шүдний өвчлөлийг бууруулах ажлын хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулахад зориулж 400,000 (дөрвөн зуун мянга) төгрөг зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 400,000 (дөрвөн зуун мянга) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, нягтлан бодогч Д.Жанчив нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (С.Ганбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Л.ЦЭНГЭЛ



Data/D

232401114